



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 287

Улаанбаатар хот

Биет бус хөрөнгө, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгалийн түүхийн музейн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 105,785,460.00 (нэг зуун таван сая долоон зуун наян таван мянга дөрвөн зуун жаран) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг Чингис хаан музейд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Эрдэнэбат, Чингис хаан музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Чулуун, Байгалийн түүхийн музейн захирал Н.Зоригтбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Биет бус хөрөнгийг хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001224

ТӨБЗГ тогтоол-/2021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 1 дугаар сарын 12-ны өдрийн
287 дугаар тогтоолын хавсралт

БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ЧИНГИС ХААН
МУЗЕЙД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Д/д	Биет бус хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ(төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо	2020	МКВ	3504	105,785,460.00
	Нийт дүн				105,785,460.00 (нэг зуун таван сая долоон зуун наян таван мянга дөрвөн зуун жар)